

# Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам

2016.07.27

№160727\01

Улаанбаатар хот

Сонгуулийн Ерөнхий Хороонд

Тайлан хүргүүлэх тухай


Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намаас УИХ-н 2016 оны сонгуулийн дараах тойргуудад өрсөлдсөн нэр дэвшигчдийн намд төвлүүлэн зарцуулсан тайланд аудитийн дүгнэлт хийлгэн танай байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж байна.

Үүнд:

- |                            |                  |
|----------------------------|------------------|
| 1. Гиймаажавын АЛТАНХУЯГ   | 12 дугаар тойрог |
| 2. Шоовдорын ТӨМӨРСҮХ      | 13дугаар тойрог  |
| 3. Атарбаярын СҮХБАТБААТАР | 52 дугаартойрогт |
| 4. Намжилжавын БАДАМХАНД   | 55 дугаартойрогт |
| 5. Ганзоригийн БАЯСГАЛАН   | 71 дүгээртойрогт |

Эдгээр нэр дэвшигчид нь намын нэгдсэн нэг дансанд хандиваа төвлөрүүлж сурталчилгааны үйл ажиллагаа явуулсан болно. Бусад нэр дэвшигчид хувийн данстай тул хуулийн дагуу тусдаа тайлангаа тавих тул намын аудитын тайланд хамрагдахгүй болно.

НАМЫН ДАРГА



Шоовдорын ТӨМӨРСҮХ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМ -ЫН УДИРДЛАГАД

Бид “Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын (цаашид “Нам” гэх) УИХ-ын 2016 сонгуулиар иргэд, хуулийн этгээдээс хүлээн авсан хандив, түүний зарцуулалтын тайланд аудит хийлээ.

#### Удирдлагын үүрэг хариуцлага

Энэхүү санхүүжилт, зарцуулалтын тайланг Монгол улсын холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн үнэн зөв бэлтгэж, толилуулах нь намын удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүжилт, зарцуулалтын тайланг алдаа зөрчилгүй бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, түүнийгээ хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

#### Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан энэхүү санхүүжилт зарцуулалтын тайлангийн талаар аудитын дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүжилт зарцуулалтын тайлан дахь дүн болон тодорүүлгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан, юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооллыг хийхтэйгээр холбоотойгоор, аудитор намын дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор намын санхүүгийн үйл ажиллагааны тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, намын удирдлагын зүгээс хийсэн томоохон

тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэдэгт бид итгэж байна.

#### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

##### Дүгнэлтийн тайлбар

Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам нь 2016 оны УИХ-ын сонгуульд нийт 5 хүн нэр дэвшүүлсэн байна. УИХ-ын 12-р тойрогт нэр дэвшигч Г.Алтанхуяг, 13-р тойрогт нэр дэвшигч Ш.Төмөрсүх, 52-р тойрогт нэр дэвшигч А.Сүхбаатар, 55-р тойрогт нэр дэвшигч Н.Бадамханд, 71-р тойрогт нэр дэвшигч Г.Баясгалан нарт нийт 79,988,000 төгрөгний хандив цугларсан байна. Намын сонгуулийн зардалд нийт 80,554,219 төгрөгийг зарцуулсан гэж бидэнд мэдээлсэн.

##### Аудитын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, дүгнэлтийн тайлбар хэсэгт дурьдсан зүйлсийг харгалзан үзсэн тохиолдолд энд хавсаргасан санхүүжилт зарцуулалтын тайлан нь УИХ-ын сонгуулийн үеэр хүлээн авсан хандив ба түүнд зориулсан зарцуулалтын санхүүгийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн байна. Түүнчлэн энэхүү санхүүжилт зарцуулалтын тайланд тусгагдсан санхүүжилт болон зарцуулалтууд нь хангалттай бөгөөд хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

*С. Андруш*

С.АНДРУШ

**ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМЫН  
СОНГУУЛИЙН ТАЙЛАН**

Тайлан гаргасан огноо: 2016 оны 7 дугаар сарын 25-ны өдөр

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн	Мөнгөн бус	Бүгд
1	1.1 Хуулийн этгээдээс өгсөн хандив	0.00	0.00	0.00
	1.2 Иргэдээс шууд өгсөн хандив	79,988,000.00		79,988,000.00
	1.3 Нам, хамтарсан нам эвслээс оруулсан орлого	0.00	0.00	0.00
	1.4 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	0.00	0.00	0.00
<b>Орлогын дүн</b>		<b>79,988,000.00</b>	<b>0.00</b>	<b>79,988,000</b>
2	2.1 Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал:	0.00	0.00	0.00
	2.2 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал:	0.00	0.00	0.00
	2.3 Нам, нэр дэвшигчийг сурталчлах зардал:	76,553,500.00	0.00	76,553,500.00
	2.4 Унааны зардал	1,390,797.60		1,390,797.60
	2.5 Бичиг хэргийн зардал	0.00	0.00	0.00
	2.6 Хөлс, урамшууллын зардал	0.00	0.00	0.00
	2.7 Түрээсийн зардал	250,000.00	0.00	250,000.00
	2.8 Бусад зардал	2,359,922.20	0.00	0.00
<b>Зардлын дүн</b>		<b>80,554,219.80</b>	<b>0</b>	<b>80,554,219.80</b>
<b>Үлдэгдэл</b>		<b>(566,219.80)</b>	<b>0</b>	<b>(566,219.80)</b>

Тайланг баталгаажуулсан:

Аудитор  
Туслах аудитор

*И. Золзая*  
*Б. Ихбаяр*

И. Золзая  
Б. Ихбаяр

